



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



ДОПИНГИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монголын Олон улсын ба үндэсний
Спортын арбитрын Ерөнхийлөгч Г.Батзаяа



ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. Спортод сэргээшийн эсрэг Копенгагены тунхаглал
(Монгол Улс 2005.04.20)
2. Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг Олон улсын конвенц
(Монгол Улс 2007.08.26)
3. Дэлхийн допингийн эсрэг дүрэм, түүний нэмэлт, хавсралтууд
4. Биеийн тамир, спортын тухай хууль (Монгол Улс
2017.07.06)
5. Үндэсний их баяр, наадмын тухай хууль (Монгол Улс
2022.06.28)
6. Допингийн эсрэг үндэсний дүрэм (Монгол Улс 2022.10.19)



СПОРТОД СЭРГЭЭШИЙН ЭСРЭГ КОПЕНГАГЕНЫ ТУНХАГЛАЛ

1. Оролцогчид өөрийн Үндсэн хууль болон бусад хуулийн заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
2. Дэлхийн Допингийн Эсрэг Агентлаг (ДДЭА)-ийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, дэмжинэ.
3. Дэлхийн Допингийн эсрэг дүрмийг дэмжих
4. Спортод Допингийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг Олон улсын болон үндэсний байгууллагууд өөрийн дүрмээ баталж, түүнийгээ дүрэмд нийцүүлэхэд нь зохих үед дэмжлэг үзүүлнэ.
5. Биелэлтийг шалгах /Конвенц эсхүл бусад баримт бичигт тусгагдсан үүргийг одоогийн үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэхийг ДДЭА болон холбогдох Засгийн газар хооронд хийсэн зөвлөгөөний үндсэн дээр шалгана/



СПОРТОД СЭРГЭЭШ ХЭРЭГЛЭХИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

1. Төрийн болон спортын байгууллагууд нягт хамтран ажиллахын зэрэгцээ бүх зохих түвшинд бие даасан, ил тод байдлыг өндөр түвшинд хангах ёстойг хүлээн зөвшөөрсөн.
2. Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг тэмцэлд тэргүүлэх үүрэгтэй байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, түүний дотор ДДЭА-тай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд туслах.
3. Энэхүү конвенцид заасан үүргийг биелүүлэхдээ оролцогч улс бүр холбогдох арга хэмжээг авах үүрэг хүлээнэ. Эдгээр арга хэмжээнд Хууль тогтоох, зохицуулах болон бодлого хэрэгжүүлэх буюу захиргааны үйл ажиллагааг багтааж болно.
4. Дотоодын зохицуулалтыг уялдуулах замаар конвенцийг биелүүлэх үүрэгтэй. Хүлээсэн үүргээ биелүүлэхдээ сэргээшийн эсрэг байгууллагууд болон спортын газар байгууллагуудтай хамтарч ажиллана.



СПОРТОД СЭРГЭЭШ ХЭРЭГЛЭХИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

5. Үндэсний хэмжээнд сэргээшийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг
 - улсын төсөвт суулгах
 - шууд татаас буюу тусламжаар,
 - спортын болон спортыг дэмжигч бүх байгууллага, сэргээшийн эсрэг байгууллагуудыг дэмжих, эсхүл тэдгээр байгууллагад хувиарлах нийт татаас буюу тусламжийн хэмжээг тооцохдоо сэргээшийн хяналтад гаргуулах зардлыг оруулах
6. Сэргээшийн эсрэг журмыг зөрчсөн аливаа спортын байгууллагууд, сэргээшийн эсрэг байгууллагуудад үзүүлж буй санхүүгийн буюу спорттой холбоотой санхүүгийн тусламжийг хэсэгчилэн эсхүл бүхлээр нь зогсоох.
7. Оролцогч улсууд энэхүү конвенцийн зорилгоор өөрсдийн хэргийн харьяалал болон оролцогч бусад улсын хэргийн харьяалалын хүрээнд сэргээш хэрэглэхийн эсрэг байгууллага, төрийн байгууллага болон спортын байгууллага хоорондын хамтын ажиллагааг олон улсын хэмжээнд дэмжинэ.



ДЭЛХИЙН ДОПНГИЙН ЭСРЭГ ДҮРЭМ

Допингийн эсрэг үндэсний байгууллага гэж улс орон бүрээс допингийн эсрэг хуулийг батлан хэрэгжүүлэх, дээж авах, дээжийн үр дүнгийн менежмент, үндэсний түвшинд сонгогч явуулах эрх үүрэг бүхий байгууллага.

Хэрэв холбогдох эрх мэдэл бүхий байгууллагаас нарийвчлан заагаагүй бол ийм байгууллага нь тухайн улсын Үндэсний Олимпын Хороо буюу түүнээс томилсон байгууллага байна.



БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

10.1.11. допингийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

Допингийн эсрэг үйл ажиллагаа

21.3. Допингийн эсрэг үндэсний дүрмийг Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

21.4. Хуульд өөрөөр заагаагүй бол допингийн эсрэг үндэсний дүрмийн дагуу хэрэгжүүлэх ажлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.



ҮНДЭСНИЙ ИХ БАЯР, НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬ

- 16.5.7. бөх, сурын харваачийг энэ хуулийн 14.2-т заасан допингийн шинжилгээнд оруулах ажлыг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагаар зохион байгуулуулах;
- 18.2. Бөх, сурын харваач, холбогдох үндэсний спортын холбоо Дэлхийн допингийн эсрэг дүрэм, эсхүл Допингийн эсрэг үндэсний дүрмийг тамирчны нэгэн адил дагаж мөрдөнө.
- 18.3. Энэ хуулийн 14.2-т заасан бөх, сурын харваачаас допингийн шинжилгээ авах арга хэмжээг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага зохион байгуулна.



ДОПИНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ДҮРЭМ (ДЭҮД)

- ДЭҮДүрмийн гол зорилго нь спортод допинг хэрэглэхтэй тэмцэх ажлыг Дэлхийн допингийн эсрэг дүрмийн хүрээнд Монгол Улсад удирдах, зохион байгуулах, хянах, допинггүй спорт бий болгоход оршино.
- Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 20.5.1-д заасны дагуу Монгол Улсад спорт дахь допингтой тэмцэх үүрэг гүйцэтгэх, допингийн эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх Засгийн газраас хараат бус Үндэсний допингийн эсрэг байгууллага ажиллана.
- Үндэсний допингийн эсрэг байгууллага нь тамирчин болон бусад этгээдийн гаргасан дүрмийн зөрчлийг хянан шийдвэрлэх, зохих шийтгэлийг оноох эрх бүхий, сонирхлын аливаа зөрчлөөс ангид, мэргэжлийн туршлагатай, үйл ажиллагааны хувьд хараат бус байх зэрэг “Үр дүнгийн удирдлагын олон улсын стандарт”-ын шаардлагыг хангасан хэрэг хянан шийдвэрлэх комиссыг байгуулна.



ДОПИНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ДҮРЭМ (ДЭҮД)

- Хэрэг хянан шийдвэрлэх комисс нь дарга, хараат бус 4 (дөрөв) гишүүнээс бүрдэнэ.
- Үндэсний допингийн эсрэг байгууллага нь тамирчин болон бусад этгээдэд энэ дүрмийн зөрчил үүссэн тухай мэдэгдсэн, тамирчин болон бусад этгээд нь Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 8.3.1, 8.3.2-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлүүлэхээс татгалзаагүй бол тус комисс нь “Үр дүнгийн удирдлага”-ын олон улсын стандартын 8, 9 дүгээр бүлэгт заасан зарчмуудыг баримтлан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна.
- Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 13.2.1 дэх заалтыг хэрэглэх боломжгүй нөхцөл байдал үүссэн үед шийдвэрийг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын давж заалдах комисст өргөдөл гаргана



ДОПИНГИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ДҮРЭМ (ДЭҮД)

- Үндэсний допингийн эсрэг байгууллага нь допинггүй спортын төлөө Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 18.2-т заасны дагуу мэдээлэл, боловсролын хөтөлбөрийг төлөвлөн, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба тамирчин болон тамирчныг дэмжигч этгээдийн идэвхтэй оролцоог хангана.
- Монгол Улсын спортын холбоод, түүний гишүүд нь Дэлхийн допингийн эсрэг дүрэм болон олон улсын стандартууд, энэ дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй.



ДДЭА-аас “ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах заавар” (2021 он)

Допингийн эсрэг үндэсний байгууллага гэж

- үндэсний хэмжээнд допингийн эсрэг дүрэм батлах, хэрэгжүүлэх,
- дээж авах ажлыг удирдан чиглүүлэх,
- үр дүнгийн удирдлагыг зохион байгуулах

үндсэн эрх, үүрэг бүхий тухайн улсаас томилогдсон аж ахуй нэгжүүд юм.

Хэрэв энэ томилгоог эрх бүхий байгууллага хийгээгүй бол тухайн байгууллага нь тухайн улсын Үндэсний олимпын хороо эсхүл түүний томилсон этгээд байдаг байна.



ҮНДЭСНИЙ ДОПИНГИЙН ЭСРЭГ БАЙГУУЛЛАГА ҮҮСГЭХ ТӨРӨЛ

1. Тухай улс төрийн байгууллага үүсгэн байгуулах /яам, төрийн захиргааны байгууллага/
2. Үндэсний олимпын хороо үүсгэн байгуулах
3. Үндэсний олимпын хорооны томилсон этгээд
4. Аж ахуй нэгж, төрийн бус байгууллага



ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Засгийн газар

- Romanian
- Spanish
- Australian
- Portugal
- Kazaskhstan

Үндэсний олимпын хороо

- Turkish

Цэвэр спортыг хамгаалах үр дүнтэй зохицуулалтыг бий болгохын тулд ҮДЭБ, Засгийн газар, үндэсний спортын байгууллагуудын үр дүнтэй ажлын харилцааг хадгалах шаардлагатай.



БИЕ ДААСАН БАЙДАЛ

ҮДЭБ нь шийдвэр гаргах, үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэх чадавхитай байна

Үйл ажиллагааны бие даасан байдал гэдэгт:

1. шинжилгээний хуваарилалт, төлөвлөлт хийх
2. шинжилгээний бүртгэлийн санг зохицуулах
3. тамирчдын биологийн паспортын менежмент хийх
4. дээжийг шинжлэх ажлыг зохион байгуулах
5. мэдээлэл цугуулж шалгалт, судалгаа хийх
6. эмчилгээний зорилгоор чөлөөлөх өргөдлүүдийг хянах
7. үр дүнгийн менежмент хийх
8. дээрхтэй холбоотой захиргааны болон шийдвэр гаргах өдөр тутмын үйл ажиллагаанууд (хүний нөөц, төсөв, үйл ажиллагааны цар хүрээ, цаг хугацаа гэх мэт) –ыг багтааж ойлгоно.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



ХАРААТ БУС БАЙДАЛ

Хараат бус байдал гэдгийг нь бусад этгээд, байгууллагын удирдлага, хяналт, зааварчилгаагүйгээр шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах эрх чөлөө гэж ойлгоно.

ҮДЭБ-ын өдөр дутмын үйл ажиллагаа, шийдвэр нь спортын байгууллага, засгийн газраас хараат бус байна

- **Спортын байгууллага:** төлбөртэй эсвэл сайн дурын үндсэн дээр олон улсын холбоо, үндэсний холбоо, томоохон арга хэмжээ зохион байгуулагч, үндэсний олимпын хороо, үндэсний паралимпийн хорооны удирдлага, үйл ажиллагаанд нэгэн зэрэг оролцож байгаа аливаа этгээд;
- **Засгийн газар:** спортын болон допингийн эсрэг асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудын удирдлага, үйл ажиллагаанд нэгэн зэрэг оролцож байгаа аливаа этгээд.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

1. ҮДЭБ-ийн гүйцэтгэх (үйл ажиллагааны) чиг үүрэгт өдөр дутмын үйл ажиллагааны үйл ажиллагааг хариуцах үүрэг багтах бөгөөд хэрэв **Засгийн газар, спортын төлөөлөгчид хяналтын үйл ажиллагаанд оролцож байгаа бол** өдөр дутмын үйл ажиллагаа нь хяналтын үйл ажиллагаанаас тусгаарлагдана;
2. Спортын болон допингийн эсрэг асуудал хариуцсан аль нэг спортын байгууллага, төрийн албанаас үйл ажиллагааны хувьд зөвшөөрөл авах шаардлагагүй, гэхдээ хөрөнгийн зарцуулалтад хариуцлага хүлээнэ.
3. Үндэсний олимпын хороо нь ҮДЭБ-ын үүргийг гүйцэтгэж байгаа тохиолдолд ҮДЭБ-ын гүйцэтгэх (үйл ажиллагааны) чиг үүргийн бие дааж хэрэгжүүлнэ. Үндэсний Олимпын Хорооны төлөөлөгчдөөс зөвшөөрөл авах шаардлагагүй, гэхдээ хөрөнгийн зарцуулалтад хариуцлага хүлээнэ.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



САНАЛ БОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ БУЮУ САЙН ТУРШЛАГА

Спортыг хариуцсан төрийн байгууллага, байгууллагууд спорт дахь допингоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч, эдгээр зорилгын төлөө хамтран ажиллаж, “хамгийн дээд зэргийн хараат бус, ил тод байдлыг зохих бүх түвшинд хангах ёстой”.

Спортын бүх төрөлд үндэсний шинжилгээний хөтөлбөрийг дэмжих, эсвэл допингийн хяналтыг шууд дэмжлэг, буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх, эсвэл тэдгээр байгууллагуудад үзүүлэх, татаас, дэмжлэгийг тодорхойлохдоо допингийн хяналтын зардлыг хүлээн зөвшөөрөх замаар спортын байгууллага, допингийн эсрэг байгууллагуудад туслах зорилгоор төсвийн хүрээнд санхүүжилт олгоно.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



САЙН ЗАСАГЛАЛ

ҮДЭБ-ын гүйцэтгэх (өдөр дутмын) чиг үүрэгт дараах зүйл багтана:

- Үйл ажиллагааныхаа хэрэгцээнд үндэслэн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хүний нөөц, дэд бүтцийг багтаасан төсвийг хуваарилах бүрэн эрх олгох
- ҮДЭБ-ын гүйцэтгэх удирдлага нь хяналтын байгууллагыг давхар тэргүүлэхийг хориглоно.
- ҮДЭБ-ын гүйцэтгэх удирдлага нь Хяналтын байгууллагын саналын эрхтэй гишүүн байхыг хориглох ба харин Хяналтын зөвлөлийн хуралд оролцож тайлан тавих эрхтэй байна

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



САЙН ЗАСАГЛАЛ

ҮДЭБ-ын хяналтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

- Хоёр байгууллагын өөр өөр чиг үүргээс шалтгаалан ҮДЭБ-ын гүйцэтгэх удирдлагаар удирдуулахгүй байх
- Хяналтын байгууллагад томилогдох шалгуурыг ойлгомжтойгоор тодорхойлох (туршлага, мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, сонирхлын зөрчилгүй байх), чөлөөлөх үндэслэл, бүрэн эрхийн хугацаа, түүнийг сунгах боломж зэргийг багтаах.
- Шийдвэр гаргах бүрэлдэхүүн нь аль нэг сонирхлын бүлэгт олонхийн саналаар өөрт ашигтай шийдвэр гаргах боломж олгохгүй байхаар тэнцвэртэй байх.
- Байгууллагын үр дүнтэй ажиллагааг хангахуйц боломжийн тоо бүхий гишүүнтэй байх. Тухайлбал, 5-9 гишүүнтэй, гишүүд нь бүгд эсвэл олонх нь Засгийн газар спортын байгууллагаас хараат бус байж жилд 1-4 удаа хуралддаг байх.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



СОНИРХЛЫН ЗӨРЧИЙН УДИРДЛАГА

ҮДЭБ нь боломжит ашиг сонирхлын зөрчил эсвэл ашиг сонирхлын зөрчилтэй мэт харагдах нөхцөл байдлын зөв менежментийг хангах шаардлагатай.

- ҮДЭБ-ын гүйцэтгэх чиг үүрэг болон хяналтын байгууллагууд нь ашиг сонирхлын зөрчилдөөний ерөнхий бодлого/ёс зүйн дүрэмтэй зөрчилдөх тохиолдолд допингийн эсрэг үйл ажиллагаатай холбоотой ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхэд үнэлгээ өгөх шаардлагатай.
- Шаардлагатай тохиолдолд ҮДЭБ нь ашиг сонирхлын зөрчлийн тусгайлсан нэмэлт бодлогыг батална.
- Бодлогод ашиг сонирхлын зөрчлийн нөхцөл байдлыг үнэлэх, шийдвэрлэх зорилгоор аппаратын ажилтнууд зэрэг бүх гишүүд болон хяналтын байгууллагын гишүүд ажилд орох, томилогдох үедээ ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгт гарын үсэг зурах, үйл ажиллагааны процессыг (жишээ нь: бууруулах, тайлагнах, шийдвэр гаргах, идэвхтэй ажлуудаас хасах гэх мэт) хэрхэн ашиглах тухай шаардлагыг тусгасан байх ёстой.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



САНХҮҮЖИЛТ БА ТӨСВИЙН УДИРДЛАГА

Санхүүжилтийн бүх эх үүсвэрийг ҮДЭБ-ын үйл ажиллагаатай холбоотой бие даасан байдлыг харуулах ил тод, хариуцлагатай байдлаар хангаж, удирдах шаардлагатай.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



ҮДЭБ-ын Гүйцэтгэх удирдлагыг томилох, шалгаруулж авах, ил тод үйл явц

- ҮДЭБ-ын Гүйцэтгэх удирдлагыг томилох үйл явц нь ил тод, улс төрөөс ангид, цаг үеэ олсон, шалгаруулалт, туршлагад суурилсан байх.
- Томилох шалгуур үзүүлэлтүүд (тухайлбал, туршлага, мэргэжлийн чадвар, сайн нэр хүндтэй байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх, гэх мэт...).

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



Засгийн газар болон спортын бусад байгууллагын өмнө ил тод, хариуцлагатай байх

- ҮДЭБ-ын эрхэм зорилго дахь олон нийтийн ашиг сонирхлын шинж чанар, цэвэр спортын төлөөх үндэсний хамтын хөдөлгөөнд нэгдэж, түүнд үнэнч оролцогч талуудын тоог харгалзан үзээд ҮДЭБ-ийн шийдвэр гаргах үйл явц ил тод (нууцлалыг алдагдуулахгүйгээр) байх нь чухал бөгөөд ҮДЭБ нь Засгийн газар болон үндэсний спортын байгууллагуудын өмнө хариуцлага хүлээнэ.
- Үйл ажиллагааны бие даасан байдал нь үнэмлэхүй байж болохгүй. Энэ нь хариуцлагатай байдал, оролцогч талуудын зохистой, тэнцвэртэй оролцоог хангасан байх ёстой. Гаргасан шийдвэрийнхээ талаар тайлагнаж, тайлбарлаж, оролцогч талуудын өмнө хариуцлага хүлээхийг ҮДЭБ-аас шаардаж болно.
- ҮДЭБ-ын хариуцлагыг ойлгомжтой тодорхойлсон байх;

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



Засгийн газар болон спортын бусад байгууллагын өмнө ил тод, хариуцлагатай байх

Сайн засаглалын хэсэг болохын тулд ҮДЭБ-ын хариуцлага нь үйл ажиллагааныхаа хариуцлагыг багтаасан байх шаардлагатай. Тухайлбал:

- ҮДЭБ-ийн жилийн үйл ажиллагааны тайланг Засгийн газар болон/эсвэл үндэсний спортын байгууллагууд, түүнчлэн ДДЭА-т танилцуулах.
- ҮДЭБ нь (олон) жилийн стратеги төлөвлөгөөг Засгийн газар болон/эсвэл үндэсний спортын байгууллагуудад танилцуулах;
- Цэвэр спортыг хамгаалахад хувь нэмрээ оруулж буй бусад сонирхлын бүлгүүдэд ҮДЭБ-ын Хяналтын байгууллагын гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл өгөх;
- Дүрэм, олон улсын стандартад заасан олон нийтэд мэдээлэх шаардлагыг дагаж мөрдөх;
- Үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн баримт бичгүүдийг нууцлалын шаардлагын дагуу олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хүргэх, нийтлэх

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



Засгийн газар болон спортын бусад байгууллагын өмнө ил тод, хариуцлагатай байх

Сайн засаглалынг хэсэг болохын хувьд ҮДЭБ-ын санхүүгийн хариуцлага нь дараах байдалтай байна.

- ҮДЭБ нь байгууллага дотроо тодорхой санхүүгийн бодлого, үйл явц, хяналтын системтэй байна.
- ҮДЭБ-ийн дансыг хараат бус хөндлөнгийн аудиторууд (эсвэл үндэсний хууль тогтоомжид заасан бол Засгийн газрын холбогдох газрууд) аудит хийх ёстой бөгөөд тайланг нь нийтэд мэдээлэх, эсхүл хамгийн багадаа Засгийн газар болон/эсвэл үндэсний спортын байгууллагад хүргүүлэх ёстой.
- ҮДЭБ нь олон нийтийн (төрийн) аудитад хамрагдаж болно.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



Засгийн газар ба үндэсний спортын захиргааны байгууллагатай хамтран ажиллах

- ҮДЭБ-ууд шийдвэр, үйл ажиллагааны хувьд спортын үндэсний байгууллага болон спорт болон допингийн эсрэг асуудал хариуцсан төрийн байгууллагаас хараат бус байхыг шаарддаг ч дүрмийн 20.4.6, 20.4.12, 20.5.3, 20.8, 22.2, 22.5-т заасан Засгийн газар, спортын байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж, мэдээлэл солилцох үүрэгтэй.
- Засгийн газар болон ҮДЭБ-ууд шээс, цусны дээжийг хязгаарлалтгүй, аюулгүй тээвэрлэх үйл явцыг бий болгох, түүнчлэн тамирчдад урьдчилан мэдэгдэлгүйгээр допингийн хяналтын ажилтнуудыг хязгаарлалтгүй оруулах, гарах журмыг бий болгоход хамтран ажиллах шаардлагатай.
- ЮНЕСКО-гийн конвенцид нийцсэн тодорхой үүрэг, хариуцлагыг тодорхойлсон допингийн эсрэг боловсролын үндэсний төлөвлөгөөтэй байж болно.

“ҮДЭБ-уудын үйл ажиллагааны хараат бус,
бие даасан байдлыг хангах заавар”



ҮДЭБ-ЫН ЗАСАГЛАЛ БА ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО

